

**Токио Гакүгэй Их Сургуулиас зохион байгуулдаг  
“Мультимедиа боловсролын сургалтын материалыг  
ашиглах олон улсын тэмцээн”**

Зүүн Азийн бүс нутгийн шилдэг багш нар цуглараарай.

**Токио Гакүгэй Их Сургуулийн  
профессор Шинохара Фүмихико**

■ **Олон улсын хамтын ажиллагааны талаар**

Токио Гакүгэй Их Сургууль нь 2004 онд хуулийн статусаа өөрчилснөөр Японы бусад их дээд сургууль төдийгүй бусад орны их дээд сургуультай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд, Япон улсын боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран олон улсыг хамарсан шинэ төсөл хэрэгжүүлж байна. 1974 оноос эхлэн хэрэгжүүлж буй ЮНЕСКО-гийн APEID буюу “Боловсролын технологи, багшийн боловсрол” гэсэн бүс байх бөгөөд ESD буюу “Тасралтгүй хөгжих боловсрол”-ын анхааралдаа авсан. Бусад хөгжилтэй орнуудтай олон улсын хамтын ажиллагааныхаа хүрээг тэлж улам гүнзгийрүүлж байна. ЮНЕСКО ганц дэлхийн өв сан гэсэн төсөл хэрэгжүүлдэг газар биш. Дэлхийн хөгжиж буй орнуудтай соёл, боловсрол, шинжлэх ухааны талаарх мэдээллийг хуваалцах, асуудлыг хамтдаа шийдэх зэрэг хэлбэрээр хамтран ажиллаж байна. Ялангуяа, боловсролын салбарын хувьд урьд өмнө нь явуулж байсан EFA буюу “Түм түмэн хүний боловсрол” гэдэг төсөл дээр нэмээд, хамгийн сүүлд 2005 оны 1сараас эхлэн 10 жилийн хугацаатай ESD хөтөлбөрийг хэрэгжүүлэх болсон. Үүнээс гадна, Японы олон улсын хамтын ажиллагаа байгууллага буюу JICA-тай хамтран “Монголын хүүхдийн хөгжлийг дэмжих заах арга зүйн шинэчлэл” төслийг хэрэгжүүлж байна. Мөн, Мультимедиагийн боловсролын хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулдаг “Мультимедиа боловсролын сургалтын материалыг ашиглах олон улсын тэмцээн”-ийг зохион байгуулдаг.

■ **Тэмцээний үндэс**

Ингээд, “Мультимедиа боловсролын сургалтын материалыг ашиглах олон улсын 2-дох тэмцээн” үнэндээ “1-дэх” нь олон улсын гэхээсээ зөвхөн Японы орон нутгийг хамарсан улсын чанартай болсон. Өөрөөр хэлбэл, ирсэн материалаас шалгаруулсан материалаа нэгдүгээр шатны шалгаруултанд

тэнцсэн гэж үзээд, хоёрдугаар шатны шалгууралтанд тус бүрд нь 20 минутын хичээл заах даалгавар өгөн “Шилдэгийн шилдэг”, “Шилдэг” гэсэн шагналын төлөө өрсөлдсөн. “Өөрийн гараараа хийсэн ч бай ч болно, худалдаанд байдаг ч зүйл ашиглаж болно. “Мультимедиаг ашигладаг улсын шилдэг багш” гэсэн өргөмжлөлийг тодруулсан юм.

Зүүн Азийн бүсийг хамарсан 2-дох тэмцээн нь “Мультимедиаг ашигладаг олон улсын шилдэг багш”-ийг шалгаруулан, шагнал олгосон нь жинхэнэ утгаараа олон улсын чанартай болсон юм.

Зохион байгуулахад Япон улсын боловсрол, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Ази номхон далайн бүсийн боловсролын хэлтэс, ЮНЕСКО-гийн Япон дах зөвлөл, Японы харах, сонсохуйн мэдрэмжийн боловсролын нийгэмлэг, Японы боловсролын их сургуулийн холбоо туслалцаа үзүүлсэн. Мөн, Ийст пресс ХХК, М Софт ХХК, Ий Стэйж ХХК, Вак Дот Ком ХХК, Ниши-Ока ханз үсгийн мэдээллийн технологийн судалгааны хүрээлэн, NTT communication ХХК зэрэг байгууллагуудад талархсанаа илэрхийлмээр байна.

Уг тэмцээн нь, схем дээр үзүүлсэнчлэн Хятадын 2 бүс, Солонгос, Тайланд, Япон гэсэн 4 газар салбараа байгуулан, тухайн бүс тус бүрдээ 1-р шатны шалгууралтыг зохион байгуулж, шалгарсан нийт 9 шилдэг багшийг Хэйсэйгийн 18-р оны 11 сарын 3-ны өдөр Токио Гакүгэй Их Сургууль дээр урин, 20 минутын хичээл заалгуулж шилдэгийн шилдэгийг тодруулах байсан. Гадаадын нийт 16 орон, дотоодын 15 хүн оролцсон. Түүнчлэн, хамтрагч холбогдох байгууллагын хүмүүс, сонирхогч, магистр, докторонтур, гадаад оюутан гээд маш олон хүн хөгжөөн дэмжиж байв. Энэ удаад шилдэгийн шилдэгийг тодруулж чадсангүй. Бүх оролцогчид “Шилдэг багш” өргөмжлөлийг олгосон нь онцлог болов.

#### ■Тэмцээний ач холбогдол

Мультимедиа боловсролын сургалтын материал эсвэл мультимедиа софтвеарын тэмцээн урд өмнө нь Японы харах, сонсохуйн мэдрэмжийн боловсролын нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж байсан “Мультимедиа урлагийн шагнал”-аас эхлээд олон тэмцээн уралдаан байв. Багш бэлтгэх нь манай сургуулийн гол зорилго бөгөөд уг тэмцээнийг зохион байгуулж байгаагийн хувьд софтын чанар, хичээл аль алинг нь шүүхэд маргах хүн байхгүй биз. Гэвч, энэ бүхнийг шүүхэд шалгуур үзүүлэлт байх хэрэгтэй бөгөөд шүүх арга болон олон байр суурьнаас харж үзэх нь чухал. Мультимедиа боловсролын сургалтын материалыг ашигласан хичээлийн зорилго, заах арга болон сургалтын зорилт гээд энэ бүгдийн цогц, мөн суралцагчийн зорилт,

хичээлийн бүтэц, багшийн үйлдэл, мультимедиагийн сургалтын материалын байр суурь, зорилт, агуулга, материалын нийлэмж, багш болон суралцагчийн софтвер болон нөлөөлөлийн хувь, багшийн амжилт, сургалтын амжилт зэрэг багш болон сургалттай хамааралтай макро болон микро хоёр талаас нь шалгуур үзүүлэлтийг боловсруулах шаардлагатай боловч судалгааны, дадлагын аль алинд ч учир дутагдалтай байгаа.

QE-Quality Education буюу “Өндөр чанартай боловсрол” гэдгийн сэдвээ болгодог олон улсын хурал, цуглаан нь даяарчлалд нийцсэн боловсролын орчинг сайжруулах явцад хөгжингүй орон, хөгжиж буй орнуудад гэж ялгалгүй дэлхийн ихэнх орнууд болон бүс нутагт төлөвлөгдөн хэрэгжиж байна. Жишээлбэл, сургуулийн боловсрол, нийтийн боловсрол, бага сургууль, 5-р анги, байгаль шинжлэлийн хичээл, хичээлийн зорилт, багшийн тактик, харилцаа, хичээлийн танхимын тоног төхөөрөмж, туршилтын багаж хэрэгсэл, туслах тоног төхөөрөмж, боловсролын медиа, багш, хүүхэд гээд “хязгаарлагдсан судалгааны зорилго”-д нийцсэн “боловсролын чанар”-т тавигдах хүчин зүйлийг цэгцэлж төрөлжүүлснээр “Өндөр чанартай боловсрол гэж юу вэ?”, “Өндөр чанартай хичээл гэж юу вэ?” гээд бодит жишээ цуглуулах явдал чухал.

Үүнийг бичигч нь 1-р шатны шалгаруултыг шүүхээр энэ оны 9-р сард Тайландын бүсийн тэмцээн дээр даяарчлалын дунд найдвар тавьж байсан

1. Indigenous Knowledge буюу Local Wisdom Тайландын Вант Улсад уламжлан дамжуулах ёстой, хөгжүүлэх ёстой, үнэт, өвөрмөц соёл, ухаан гэсэн үзэл хангалттай шингээсэн байдал, 2. Суралцагчийн сонирхолыг татан тэдний эргэн тойронд байдаг үзэгдэл зэрэгтэй холбон багш, суралцагч хоёрын харьцаа, харилцааг сонирхолтой, ач холбогдолтой болгосон байдал, 3. Хүрээлэн байгаа орчинд хандах хандлага, 4. Гэр бүл болон бүс нутгийн хоорондын холбооны чухалыг ойлгуулах, 5. Бусдын үзэл бодлын ялгааг хүлээн зөвшөөрөх зэрэг зүйлс “Мультимедиа боловсролын сургалтын материалыг ашиглах тэмцээн”-ий “Шилдэг багш”-ийг шалгаруулахад нийтлэг үзүүлэлт болж, түүний дараагаар 6. суралцагчийн хичээлд оролцох байдал, 7. Суралцагч болон багшийн сэтгэл ханамж, 8. Асуултанд хариулах байдал болон ойлголт зэрэг үзүүлэлтийг бүх шүүгчид шүүнэ. Энэ талаар тэмцээний төгсгөлд дурдсан болно.

“Олон улсын тэмцээнийг зохион байгуулах хороо”-ны хуралдаанаар ирэх жилийн тэмцээнийг Хятадын Шанхай хотод хийхээр болсон бөгөөд Монгол, Энэтхэг зэрэг орнуудыг шинээр оролцуулахыг санал нэгтэй батлав. Ингээд бидний зохион байгуулж буй тэмцээн маань Зүүн Азиас Төв, Өмнөд Ази гээд шилдэг багш нарынхаа хүрээг тэлж байна.